



**ИНД - 133**

Иргэний Нисэхийн Дүрэм

**Нисдэг тэрэгний дүүжинт тээврийн үйл ажиллагаа**

Иргэний нисэхийн ерөнхий газар

## **ДҮРМИЙН ТАЙЛБАР**

ИНД-133 нь нисдэг тэргээр дүүжинт тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээдэд хамаарах, ИНД-91-д заасан ерөнхий үйл ажиллагааны болон нислэгийн дүрмийн нэмэлт шаардлага, мөн түүнд үл хамаарах шаардлагыг тогтооно.

ИНД-133 нь нисдэг тэрэгний өөхийд бэхэлсэн татлагаар хүн зөөх, эсхүл спортын, эсхүл сургалтын зорилгоор нисдэг тэргээр хүн чирэх үйл ажиллагаанд хамаарахгүй.

**Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-133-ын цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-133, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл [www.mcaa.gov.mn](http://www.mcaa.gov.mn) веб сайтаас татаж авах боломжтой.**

**Мэдээлэл**

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн дүрмийг боловсруулсан.

**Өөрчлөлтийн түүх****Хүчинтэй огноо**

Анхны боловсруулалт

2001 оны 10 сарын 01

Нэмэлт, өөрчлөлт 1

2010 оны 05 сарын 07

Нэмэлт, өөрчлөлт 2 (Шинэчлэлт)

2018 оны ... сарын ...

**Тэмдэглэл:** ИНД-133-ын шинэчлэлтийг монгол, англи хэл дээр, NZ Part 133 А.3-д үндэслэн боловсруулсан болно.

## Гарчиг

<b>А Бүлэг - Ерөнхий зүйл</b> .....	<b>5</b>
133.1. Хамрах хүрээ .....	5
133.3. Тодорхойлолт .....	5
133.5. Нисгэгчийн үнэмлэхний шаардлага. ....	5
<b>В Бүлэг - Үйл ажиллагааны дүрэм болон холбогдох шаардлага</b> .....	<b>6</b>
133.51. Минимум аюулгүй өндөр .....	6
133.53. Хүн тээвэрлэх .....	6
133.55. Гуравдагч этгээдийн эрсдэл .....	7
133.57. Жингийн хязгаарлалт .....	7
133.59. Ил харааны нислэгийн дүрэм .....	7
133.61. Шөнийн үйл ажиллагаа .....	7
133.63. Ачаа тээвэрлэх .....	8
133.65. Аюултай бараа .....	8
133.67. Нислэгийн үзүүлэлт .....	9
133.69. Шигүү суурьшлын бүс дээгүүрх үйл ажиллагаа .....	9
133.71. Нисдэг тэрэгний өөхийд татлагаар хүн зөөх .....	9
133.73. Багийн нэмэлт гишүүн.....	11
133.75. Багийн гишүүдийн ур чадвар.....	11
<b>С Бүлэг - Нөөц</b> .....	<b>12</b>
<b>Д Бүлэг - Нөөц</b> .....	<b>12</b>
<b>Е Бүлэг - Нөөц</b> .....	<b>12</b>
<b>Ү Бүлэг – Хэрэглэл болон Төхөөрөмж</b> .....	<b>12</b>
133.251. Хамрах хүрээ .....	12
133.253. Ерөнхий зүйл .....	12
133.255. Дүүжинт ачааны төхөөрөмж .....	13
133.257. Түргэн салгах төхөөрөмж.....	13
<b>Г Бүлэг - Техник үйлчилгээ</b> .....	<b>14</b>
133.301. Хамрах хүрээ .....	14
133.303. Техник үйлчилгээний шаардлага .....	14
133.305. Техник үйлчилгээг гэрчилгээжүүлэх этгээд .....	14
133.307. Дүүжинт ачааны төхөөрөмж .....	14

## А Бүлэг - Ерөнхий зүйл

### 133.1. Хамрах хүрээ

(a) ИНД-133 нь нисдэг тэргээр дүүжинт тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээдэд хамаарах, ИНД-91-д заасан ерөнхий үйл ажиллагааны болон нислэгийн дүрмийн нэмэлт шаардлага, мөн түүнд үл хамаарах шаардлагыг тогтооно.

(b) ИНД-133 нь нисдэг тэрэгний өөхийд бэхэлсэн татлагаар хүн зөөх, эсхүл спортын, эсхүл сургалтын зорилгоор нисдэг тэргээр хүн чирэх үйл ажиллагаанд хамаарахгүй.

### 133.3. Тодорхойлолт

Энэ Дүрэмд:

**Нисдэг тэрэгний дүүжинт тээврийн үйл ажиллагаа** гэж:

- (1) нисдэг тэргээр дүүжинт ачаа чирэх үйл ажиллагаа ; эсхүл
- (2) нисдэг тэрэгний татлагат ачааны үйл ажиллагаа; эсхүл
- (3) нисдэг тэрэгний татлагаар өргөж, буулгах үйл ажиллагаа; эсхүл
- (4) нисдэг тэрэгнээс олсоор буулгах үйл ажиллагааг ойлгоно.

**Нисдэг тэргээр дүүжинт ачаа чирэх үйл ажиллагаа** гэж нисдэг тэрэгний үйл ажиллагааны үед тухайн ачаа нь газартай харьцсан хэвээр байдаг дүүжинт ачааг чирэх, буулгах ба хэвтүүлэх үйл ажиллагааг.

**Нисдэг тэрэгний татлагат ачааны үйл ажиллагаа** гэж нисдэг тэрэгний өөхийд бэхэлсэн сагс, тор, даруулга бэхэлгээ, татлага, эсхүл дамнуурга ашиглан ачаа, карго, эсхүл зорчигчийг нисдэг тэрэгний гадна талд тээвэрлэх, буулгах, эсхүл авах үйл ажиллагааг.

**OGE** - Газрын нөлөөгүй (out of ground effect)

### 133.5. Нисгэгчийн үнэмлэхний шаардлага.

(a) Нисдэг тэргээр дүүжинт тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа хөлгийн дарга нь дараах үүрэгтэй:

- (1) коммерийн нисгэгчийн хүчинтэй үнэмлэх (нисдэг тэрэгний) эзэмшдэг байх, эсхүл
- (2) хувийн нисгэгчийн хүчинтэй үнэмлэх (нисдэг тэрэгний) эзэмшдэг байх, хэрэв тухайн нисгэгч нь ИНД-61.153-д шаардсан татлагат ачаа тээвэрлэх сургалтыг амжилттай төгссөн болохыг багш нисгэгч нислэгийн дэвтэрт нь баталгаажуулсан бол.

(b) Энэ зүйлийн (a)(2)-ыг үл харгалзан, татлагаар өргөж буулгах, олсоор буулгах, эсхүл татлагаар хүн зөөх ажиллагааг нисдэг тэргээр гүйцэтгэж байгаа хөлгийн дарга нь коммерийн нисгэгчийн хүчинтэй үнэмлэх (нисдэг тэрэгний) эзэмшдэг байх үүрэгтэй.

(с) Энэ зүйлийн (а), (b)-г үл харгалзан, сургалтад хамрагдаж байгаа нисгэгч нь хэрэв, тухайн үйл ажиллагааг гүйцэтгэхийн өмнө багш нисгэгчийн зэрэглэл (нисдэг тэрэг) эзэмшигч зөвшөөрсөн бол, коммерийн (нисдэг тэрэг), эсхүл хувийн нисгэгчийн (нисдэг тэрэг) хүчинтэй үнэмлэхгүйгээр нисдэг тэрэгний дүүжин ачааны сургалтын үйл ажиллагаанд хөлгийн даргын үүрэг гүйцэтгэж болно.

## **В Бүлэг - Үйл ажиллагааны дүрэм болон холбогдох шаардлага**

### **133.51. Минимум аюулгүй өндөр**

(а) ИНД-91.311-ийг үл харгалзан, нисдэг тэргээр дүүжинт тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисдэг тэрэгний хөлгийн дарга нь, хэрэв тухайн үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай бол, гадаргуу дээрх хүн, өмч хөрөнгөнд аюул учруулахгүй байх зохих анхаарал тавьсан тохиолдолд, ойртолт, хөөрөлт болон ачааг байрлуулах манерыг багтаасан үйл ажиллагааг гадаргуугаас дээш 150м-ээс (500ft) нам өндөрт, хүн, усан онгоц, тээврийн хэрэгсэл болон байгууламжаас 150м-ээс дотогш зайд гүйцэтгэж болно.

(b) Нисдэг тэргээр дүүжинт тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисдэг тэрэгний хөлгийн дарга, тухайн нислэг нь дүүжин ачааг салган хаях (jettisonable) болон нисдэг тэрэг онцгой нөхцөлийн үед газар дээрх хүн, эсхүл өмч хөрөнгөнд аюул учруулахгүйгээр буулт үйлдэх боломжтой өндөр болон замаар гүйцэтгэгдэж байгааг бататгахад зохих анхаарал тавих үүрэгтэй.

### **133.53. Хүн тээвэрлэх**

(а) Хөлгийн дарга нь нисдэг тэргээр дүүжинт ачаа чирэх үйл ажиллагаа гүйцэтгэхдээ, тухайн дүүжинт ачаа чирэх ажиллагаанд зайлшгүй үүрэг гүйцэтгэхгүй этгээдийг тухайн нисдэг тэргэнд тээвэрлэхгүй.

(b) Хөлгийн дарга нь дараахаас бусад тохиолдолд, нисдэг тэрэгний татлагат ачааны үйл ажиллагаа гүйцэтгэхдээ, тухайн нисдэг тэрэгний татлагат ачааны үйл ажиллагаанд зайлшгүй үүрэг гүйцэтгэхгүй этгээдийг тухайн нисдэг тэргэнд тээвэрлэхгүй:

- (1) тухайн үйл ажиллагаа нь татлагаар хүн зөөх ажиллагаа биш байх;
- (2) тухайн этгээд нь татлагаар ачаа тээвэрлэхтэй холбоотой ажлыг, үйл ажиллагаа хийгдэх тухайн газарт гүйцэтгэх шаардлагатай байх;
- (3) тухайн үйл ажиллагааны аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй байх.

(с) Хөлгийн дарга нь нисдэг тэргээр татлагаар өргөж буулгах, олсоор буулгах, эсхүл татлагаар хүн зөөх үйл ажиллагаа гүйцэтгэхдээ, тухайн татлагаар өргөж буулгах, олсоор буулгах, эсхүл татлагаар хүн зөөх ажиллагаанд зайлшгүй үүрэг гүйцэтгэхгүй этгээдийг тухайн нисдэг тэргэнд тээвэрлэхгүй.

(d) Энэ зүйлийн (а), (b) болон (с)-г үл харгалзан, хөлгийн дарга нь, тухайн үйл ажиллагаанд зайлшгүй үүрэг гүйцэтгээгүй, нислэгийн бүхээгт дадлага хийж байгаа

багийн гишүүнийг тухайн нисдэг тэргэнд дараах шаардлага хангагдсан бол тээвэрлэж болно:

- (1) хөлгийн дарга нь тухайн гүйцэтгэх үйл ажиллагааны төрөлд зааварчилгаа өгөхөөр мэргэшсэн байх;
- (2) тухайн үйл ажиллагааны аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй байх.

### **133.55. Гуравдагч этгээдийн эрсдэл**

(a) Хөлгийн дарга нь дараах байдлаар, нисдэг тэрэгний өөхийд бэхэлсэн татлагаар ачаа тээвэрлэхгүй:

- (1) тухайн этгээдээс зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд, аливаа хувь хүн, эсхүл этгээдийн өмч хөрөнгөнд аюул учруулах хэлбэрээр;
- (2) олон хүн цугларсан задгай талбай дээгүүр.

(b) Энэ зүйлийн (c)-д зааснаас бусад тохиолдолд, дүүжинт тээврийн үйл ажиллагаанд оролцон, дүүжин нислэг хийж байгаа нисдэг тэрэгний хөлгийн дарга нь, нисдэг тэрэгний дүүжин нислэгийн бүсэд тухайн үйл ажиллагаанд оролцох зайлшгүй шаардлагатай бөгөөд дараах зааварчилгаа авснаас бусад этгээд байхгүй болохыг бататгана:

- (1) дүүжинт ачаа тээвэрлэх хэвийн нөхцөлийн журам;
- (2) онцгой нөхцөлийн үед бүх ажилтны мөрдөх журам;
- (3) тухайн ачааны онцлог ба үйлчилгээний тусгай шаардлага;
- (4) тухайн нисдэг тэрэгний өргөх чадал;
- (5) тухайн үйл ажиллагаатай холбоотой гараар өгөх, эсхүл радио дохио.

(c) Энэ зүйлийн (b)-г газарт байгаа бэртсэн хүнд тусламж үзүүлж байгаа тохиолдолд мөрдөхийг шаардахгүй.

### **133.57. Жингийн хязгаарлалт**

Нисдэг тэргээр дүүжинт тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисдэг тэрэгний хөлгийн дарга, тухайн тээвэрлэх ачааны жин нь 133.255(1)-д шаардсан ачааны өргөх дэгээ, эсхүл хэрэгслийн жингийн хязгаарлалтаас хэтрээгүй болохыг бататгана.

### **133.59. Ил харааны нислэгийн дүрэм**

Нисдэг тэргээр дүүжинт тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисдэг тэрэгний хөлгийн дарга, тухайн үйл ажиллагаа нь ИХНД-ийн дагуу гүйцэтгэгдэж байгааг бататгана.

### **133.61. Шөнийн үйл ажиллагаа**

Хөлгийн дарга, тухайн нисдэг тэрэгний нислэгийн байрлал, өндөр болон байршлыг нисдэг тэрэгний гэрэл, газрын гэрэл, эсхүл байгалийн гэрлээр хангалттай

гэрэлтүүлсэн гадны баримжаат цэгээр хадгалж чадахгүй үед, шөнийн цагаар нисдэг тэргээр дүүжинт тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэхгүй.

### **133.63. Ачаа тээвэрлэх**

Нисдэг тэргээр дүүжинт тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа хөлгийн дарга нь тухайн тээвэрлэх ачааг 133.255(1)-д шаардсан өргөх дэгээ, эсхүл хэрэгслийг ашиглан тээвэрлэж байгааг бататгана.

### **133.65. Аюултай бараа**

(а) Нисдэг тэрэгний хөлгийн дарга, дараах тохиолдолд ИНД-92-ыг мөрдөхгүйгээр, нисдэг тэргээр Ангилал 1-ийн аюултай барааг нисдэг тэрэгний өөхийд дүүжин хэлбэрээр тээвэрлэхээр хүлээн авч болно, хэрэв:

- (1) тухайн аюултай барааг ИНД-92-т заасан зөвшөөрөгдсөн гүйцэтгэгч тээвэрлэхийг зөвшөөрсөн бол;
- (2) тухайн аюултай барааг тээвэрлэх аюулгүй байдлын болон онцгой нөхцөлийн журмыг тогтоосон бол.
- (3) тухайн аюултай барааг:
  - (i) агаараар тээвэрлэх тохиромжтой нөхцөлд;
  - (ii) аюулгүй тээвэрлэлтэд зориулан байрлуулсан ба бэхэлсэн бол.
- (4) тухайн ажиллагааг хот, эсхүл суурингийн шигүү суурьшлын бүсээс зайтай гүйцэтгэх бол.

(б) Нисдэг тэрэгний хөлгийн дарга, дараах тохиолдолд ИНД-92-ыг мөрдөхгүйгээр, нисдэг тэргээр Ангилал 2-оос Ангилал 9-ийн аюултай барааг нисдэг тэрэгний өөхийд дүүжин хэлбэрээр тээвэрлэхээр хүлээн авч болно, хэрэв:

- (1) тухайн аюултай барааны тээвэрлэлтийг Техник зааварчилгаанд хориглоогүй бол;
- (2) тухайн аюултай барааг тээвэрлэх аюулгүй байдлын болон онцгой нөхцөлийн журмыг тогтоосон бол;
- (3) тухайн аюултай барааны эд зүйл бүрийг таньж тогтоосон бол;
- (4) тухайн аюултай барааны аюултай шинж чанарыг хөлгийн даргад мэдэгдсэн бол;
- (5) тухайн аюултай бараа нь:
  - (i) агаараар тээвэрлэх тохиромжтой нөхцөлд байгаа бол;
  - (ii) хэрэв хоорондоо аюултай байдлаар урвалд орж болох бол, тусгаарлагдсан байх;
  - (iii) байрлуулагдсан, бэхлэгдсэн байх ба хэрэв шаардлагатай бол, нислэгийн үед асгарах, эсхүл гэмтэхээс сэргийлэхээр савлагдсан байх.



**133.67. Нислэгийн үзүүлэлт**

(a) Нисдэг тэргээр дүүжинт тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисдэг тэрэгний хөлгийн дарга нь, нисдэг тэрэг тухайн ачааллын бүсийг орхихоос өмнө ачааг зөв тохируулсан, байрлуулсан болохыг бататгана.

(b) Нисдэг тэргээр дүүжинт тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисдэг тэрэгний хөлгийн дарга нь тухайн нисдэг тэрэг, ачааг бүрэн хянаж байх хэлбэр болон нөхцөлд нислэг үйлдэнэ.

**133.69. Шигүү суурьшлын бүс дээгүүрх үйл ажиллагаа**

Хот, эсхүл суурингийн шигүү суурьшлын бүс дээгүүр, эсхүл түүний дэргэд нисдэг тэргээр дүүжинт тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисдэг тэрэгний хөлгийн дарга нь дараах үүрэгтэй:

- (1) дараах мэдээллийг багтаасан тухайн үйл ажиллагаатай холбоотой төлөвлөгөөг бэлтгэх ба үйл ажиллагаанд оролцох бүх хүмүүст зааварчилгаа өгөх:
  - (i) нислэгийн зам, түвшинг заасан зураг;
  - (ii) нислэгт учирч болох саадаас зайлсхийх арга зам;
  - (iii) тухайн нисдэг тэргэнд ноцтой доголдол гарсан тохиолдолд авах арга хэмжээний дэлгэрэнгүй мэдээлэл;
  - (iv) тухайн үйл ажиллагааг гадаргуу дээрх хүн, эсхүл өмч хөрөнгөнд аюул учруулахгүйгээр гүйцэтгэх боломжит арга хэмжээ авсныг бататгах, Монгол Улсын Стандартын эрх бүхий байгууллагаас гаргасан Эрсдэлийн Менежментийн Стандартын дагуу боловсруулсан эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийг бууруулах журам;
  - (v) НХУ-ын үйлчилгээтэй хийх аливаа шаардлагатай зохицуулалт;
- (2) энэ зүйлийн (1)-д заасан төлөвлөгөөг тухайн үйл ажиллагааг гүйцэтгэсэн өдрөөс хойш 6 сараас доошгүй хугацаанд хадгалах;
- (3) холбогдох нутгийн захиргааны эрх бүхий байгууллагад бичгээр урьдчилан мэдэгдэх;
- (4) тухайн нутгийн захиргааны эрх бүхий байгууллагын аливаа шаардлагыг мөрдөх;
- (5) тухайн гүйцэтгэх үйл ажиллагааны талаар олон нийтэд үр дүнтэй хэлбэрээр урьдчилан мэдээлэх.

**133.71. Нисдэг тэрэгний өөхийд татлагаар хүн зөөх**

(a) Нисдэг тэрэгний өөхийд бэхэлсэн татлагаар хүн зөөх үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа хөлгийн дарга нь дараах шаардлагыг хангасан болохыг бататгана:

- (1) тухайн нисдэг тэрэг нь газрын нөлөөгүй дүүжин нислэг үйлдэх жингийн 90 хувиас хэтэрсэн жинтэй үйл ажиллагаа гүйцэтгэхгүй байх;

- (2) тухайн хүнийг тээвэрлэх зай нь, тухайн үйл ажиллагааны зорилгыг биелүүлэхэд шаардлагатай минимум зайд байх;
  - (3) тухайн хүнийг бэхэлсэн татлагат төхөөрөмжийг нисдэг тэрэгнээс багийн гишүүн салгах боломжтой байх ба салгах систем нь түүнийг салгахын тулд хоёр тусдаа үйлдэл хийх ёстой байхаар зохицуулагдсан байх;
  - (4) тухайн хүнийг бэхэлсэн татлагат төхөөрөмж нь санамсаргүйгээр салгах боломжгүй хэлбэрээр хийгдсэн байх;
  - (5) тухайн нисдэг тэрэг нь дараах аюулгүй маневрын талбайд үйл ажиллагаа гүйцэтгэх:
    - (i) диаметр нь тухайн нисдэг тэрэгний нийт уртаас хоёр дахин их;
    - (ii) тухайн нисдэг тэрэгний хамгийн доор бэхлэгдсэн хэсгээс доош, босоо тэнхлэгт нэг метрийн дотор саадгүй;
    - (iii) татлагаар өргөж буулгах, олсоор буулгах, эсхүл татлагаар хүн зөөх саадгүй бүс.
- (b) Нисдэг тэрэгний хөлгийн дарга нь нисдэг тэрэгний өөхийд бэхэлсэн татлагаар хүн өргөх, эсхүл буулгахдаа дараах шаардлагыг бататгана:
- (1) тухайн буулгах хүний суудлын даруулга бүсийг тайлахаас өмнө татлагад бэхэлсэн болохыг;
  - (2) дээш өргөгдөх хүний татлагыг тайлахын өмнө аюулгүйн оосор, эсхүл суудлын даруулгаар бэхэлсэн болохыг;
  - (3) тухайн хүн ухаан алдсан, эсхүл ойлгох чадваргүй байхаас бусад тохиолдолд, нисдэг тэрэгний багийн гишүүн тухайн хүнд үйл ажиллагаатай холбоотой хэвийн болон онцгой нөхцөлийн журмын зааварчилгаа өгсөн болохыг.
- (c) Нисдэг тэрэгний хөлгийн дарга нь бэртэж гэмтсэн хүнийг нисдэг тэрэгний өөхийгөөс бэхэлсэн бэхэлгээ, эсхүл дамнуургаар тээвэрлэх үед дараах нөхцөлийг бататгана:
- (1) тухайн этгээдийг тээвэрлэх зай нь дараах ажиллагаанд шаардлагатай минимум зайд байх:
    - (i) тухайн этгээдийг илүү тохиромжтой тээврийн хэрэгсэлд шилжүүлэх; эсхүл
    - (ii) аюулгүй буулт үйлдэж тухайн татлагаар тээвэрлэж байгаа хүнийг нисдэг тэргэн дотор шилжүүлэх.
  - (2) тухайн хүн ухаан алдсан, эсхүл ойлгох чадваргүй байхаас бусад тохиолдолд, нисдэг тэрэгний багийн гишүүн тухайн хүнд үйл ажиллагаатай холбоотой хэвийн болон онцгой нөхцөлийн журмын зааварчилгаа өгсөн болохыг.
- (d) Нисдэг тэрэгний хөлгийн дарга олсоор буулгах үйл ажиллагааг гүйцэтгэхдээ, тухайн олсоор буух хүн дараах шаардлага хангасныг бататгана:
- (1) гүйцэтгэж байгаа олсоор буулгах үйл ажиллагаатай холбоотой сургалтын курсыг амжилттай дүүргэсэн байх;

- (2) тухайн үйл ажиллагаатай холбоотой хэвийн болон онцгой нөхцөлийн журмын талаар багийн гишүүнээс зохих зааварчилгаа авсан байх;
- (3) суудлын даруулгаа тайлахаас өмнө тухайн олсонд зүүгдсэн байх.

### **133.73. Багийн нэмэлт гишүүн**

(а) Нисдэг тэргээр дүүжинт тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисдэг тэрэгний хөлгийн дарга, багийн нэмэлт гишүүн бүр нь дараах шаардлага хангаж байгааг бататгана:

- (1) хөлгийн дарга дараах үйл ажиллагааг гүйцэтгэх боломжгүй үед:
  - (i) татлагаар өргөж, буулгах төхөөрөмжийг ажиллуулах; эсхүл
  - (ii) ачааг хянах; эсхүл
  - (iii) ачааг салгах; эсхүл
  - (iv) саадыг ажиглах; эсхүл
  - (v) хүмүүсийг суулгах, буулгах.
- (2) хөөрөлтийн өмнө тухайн үйл ажиллагаа болон гүйцэтгэх тусгай үүргийн талаар бүрэн зааварчилгаа авсан байх;
- (3) онцгой нөхцөлийн үед хялбар тайлах боломжтой, гэхдээ санамсаргүй байдлаар тайлагддаггүй даруулгаар бэхлэгдсэн байх;
- (4) нисгэгчтэй хоёр талын холбоо барих боломжтой системээр хангагдсан байх.

### **133.75. Багийн гишүүдийн ур чадвар**

(а) Багийн бүх гишүүд нь тухайн үйл ажиллагаа, агаарын хөлөг, тоног төхөөрөмжтэй холбоотой хэвийн болон онцгой нөхцөлийн маневрыг гүйцэтгэх чадвар, техникийн мэдлэг болон ур чадвараа харуулах шалгалт өгсөн, эсхүл нислэгийн үнэлгээг амжилттай хийлгэсэн байхаас бусад тохиолдолд, үйл ажиллагаа эрхлэгч нь татлагаар өргөж буулгах, олсоор буулгах, эсхүл татлагаар хүн зөөх үйл ажиллагаа гүйцэтгэхийг зөвшөөрөхгүй.

(b) Энэ зүйлийн (а)-д заасан шалгалт, эсхүл нислэгийн үнэлгээг дараах шаардлагын дагуу гүйцэтгэнэ:

- (1) дараах гэрчилгээ эзэмшигч:
  - (i) тухайн эзэмшигчийг шалгалт авах, эсхүл нислэгийн үнэлгээ хийхийг зөвшөөрсөн, ИНД-119-ийн дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ; эсхүл
  - (ii) тухайн эзэмшигчийг шалгалт авах, эсхүл нислэгийн үнэлгээ хийхийг зөвшөөрсөн, ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ;
- (2) тухайн багийн гишүүний шаардлагатай маневрыг гүйцэтгэх чадварт зохих ёсоор үнэлгээ хийх боломжтой агаарын хөлөгт;

(3) тухайн нислэгийг үйлдэхийн өмнөх 24 сарын хугацаанд.

(с) Энэ зүйлийн (а)-д заасан шалгалт, эсхүл нислэгийн үнэлгээ нь тухайн үйл ажиллагаанд гарч болох бүх хэвийн, онцгой нөхцөлийн болон дараах шаардлагыг багтаасан байна:

- (1) нислэгт бэлтгэх;
- (2) багийн менежмент;
- (3) зорилгот байг тодорхойлох ба нисдэг тэргийг зөв байрлуулах;
- (4) холбоо алдагдах;
- (5) хэвийн бус нөхцөлд ажилтны ажиллах журам;
- (6) нисдэг тэрэгний сэрэмжлүүлэх гэрэл;
- (7) хөдөлгүүрийн чадал алдагдах;
- (8) цахилгаан тэжээл татгалзах.

(d) Нисдэг тэргээр дүүжинт тээврийн үйл ажиллагаа эрхлэгч нь бүх шалгалтын болон нислэгийн үнэлгээний бүртгэлийг 4-өөс доошгүй жил хадгална.

(е) Сургалтын зорилгоор нисдэг тэргээр дүүжинт тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа хөлгийн дарга нь хот, тосгон, эсхүл суурингийн дээгүүр, эсхүл түүний дэргэд тухайн үйл ажиллагаа гүйцэтгэхгүй байхыг бататгана.

## **С Бүлэг - Нөөц**

## **Д Бүлэг - Нөөц**

## **Е Бүлэг - Нөөц**

## **F Бүлэг – Хэрэглэл болон Төхөөрөмж**

### **133.251. Хамрах хүрээ**

Энэ Бүлэг нь ИНД-91-ийн шаардлага дээр нэмж, нисдэг тэргээр дүүжинт ачаа тээвэрлэхэд шаардлагатай хэрэглэл, төхөөрөмжийг тогтооно.

### **133.253. Ерөнхий зүйл**

(а) Нисдэг тэргээр дүүжинт тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа үйл ажиллагаа эрхлэгч, тухайн хэрэглэл, төхөөрөмж нь энэ Бүлгийн дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, тухайн нислэг эхлүүлэхгүй байхыг бататгана:

- (1) дараах баримт бичигт заасан техникийн үзүүлэлт болон НТЧ-ын загварын стандартыг хангасан байх:

- (i) энэ Бүлэг; эсхүл
  - (ii) тухайн үйл ажиллагааны хувьд, Даргын баталсан өөр орлох техникийн үзүүлэлт болон стандарт;
- (2) үйл ажиллагааны болон НТЧ-ын шаардлагыг багтаасан, тэдгээрт хамааралтай шаардлагын дагуу суурилуулагдсан байх;
- (3) ажиллагаатай нөхцөлд байх бөгөөд тухайн гүйцэтгэх үйл ажиллагааны төрөлд шаардлагатай тоотой байх.

### **133.255. Дүүжинт ачааны төхөөрөмж**

Нисдэг тэргээр дүүжинт тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн нисдэг тэргийг дараах хэрэглэлээр тоногдсон болохыг бататгах үүрэгтэй:

- (1) тухайн нисдэг тэргэнд ашиглахыг нисдэг тэрэг үйлдвэрлэгч зөвшөөрсөн, эсхүл ИНД-21, С Бүлгийн хүрээнд загварын өөрчлөлтийн дагуу зөвшөөрсөн ба суурилуулсан ачааны өргөх дэгээ, эсхүл түүнтэй төстэй төхөөрөмж;
- (2) дараах дүүжинт ачааны төхөөрөмж:
- (i) тохирсон ба өөрөө эвдрэх, эсхүл нисдэг тэргийг гэмтээхээс сэргийлсэн стандартын;
  - (ii) тухайн төхөөрөмжийг ашиглан хүн тээвэрлэх тохиолдолд, тухайн даацын жингээс 3.75 дахин их ачаалал даах чадвартай.

### **133.257. Түргэн салгах төхөөрөмж**

(a) Нисдэг тэргээр дүүжинт тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн нисдэг тэрэг дараах төхөөрөмжөөр тоноглогдсон болохыг бататгана:

- (1) түргэн салгах цахилгаан төхөөрөмж;
- (2) механик, эсхүл бие даасан, хамааралгүй түргэн салгах цахилгаан төхөөрөмж.

(b) Үйл ажиллагаа эрхлэгч, энэ зүйлийн (a)-д шаардсан түргэн салгах төхөөрөмж нь тухайн нисдэг тэрэгний максимум дүүжинт ачааг багтаасан, бүх дүүжинт ачааны даацанд тохирч байгааг бататгана.

(c) Үйл ажиллагаа эрхлэгч, тухайн түргэн салгах систем нь дараах шаардлага хангасныг бататгана:

- (1) үндсэн удирдлага нь:
- (i) аль нэг нисгэгчийн үндсэн нислэгийн удирдлага дээр суурилуулагдсан байх;
  - (ii) онцгой нөхцөлийн үед нисгэгч түүнийг ажиллуулахад, тухайн нисдэг тэргийг удирдах нисгэгчийн чадварыг хязгаарлахгүй байхаар зохион бүтээгдэж, байрлуулсан байх.
- (2) багийн гишүүн хялбар хүрч хэрэглэх боломжтой хоёрдогч удирдлагатай байх.

## **G Бүлэг - Техник үйлчилгээ**

### **133.301. Хамрах хүрээ**

Энэ Бүлэг нь дүүжинт ачаа тээвэрлэх Монгол Улсын бүртгэлтэй нисдэг тэрэгний техник үйлчилгээний шаардлагыг тогтооно.

### **133.303. Техник үйлчилгээний шаардлага**

Үйл ажиллагаа эрхлэгч нь 133.255(1)-д шаардсан ачааны өргөх дэгээ, эсхүл түүнтэй төстэй бусад төхөөрөмжийг багтаасан, тухайн нисдэг тэрэгний техник үйлчилгээг ИНД-91 болон энэ Дүрмийн дагуу хийдэг болохыг бататгана.

### **133.305. Техник үйлчилгээг гэрчилгээжүүлэх этгээд**

Үйл ажиллагаа эрхлэгч нь, ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх этгээд бүр зохих ёсоор сургалтад хамрагдаж, тухайн гэрчилгээжүүлэлтийг хийхээр мэргэшсэн болохыг бататгана.

### **133.307. Дүүжинт ачааны төхөөрөмж**

(a) Үйл ажиллагаа эрхлэгч, дүүжинт ачааны төхөөрөмж нь дараах шаардлага хангасныг бататгана:

- (1) хэвийн бус байдлын шинж тэмдгийг шалгах нүдэн үзлэгийг өмнөх ашиглалтын 50 цаг тутамд хийсэн байх;
- (2) өмнөх 12 сар, эсхүл ашиглалтын 500 цагийн аль түрүүлж болох хугацаанд, түүний тооцоот ачааллаас 1.25 дахин их ачаалал өгч шалгасан байх.

(b) Үйл ажиллагаа эрхлэгч нь, энэ зүйлийн (a)-д заасан, дүүжинт ачааны төхөөрөмжийн үйлчилгээг орлох засвар үйлчилгээг дараах хуваарийн дагуу хийж болно:

- (1) заавал мөрдөх солих хугацаа, үзлэгийн хуваарь болон үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний заавар, эсхүл НТЧ-ын байнгын хадгалалтын зааварчилгаанд заасан холбогдох журам; эсхүл
- (2) ИНД-91, эсхүл ИНД-119-ийн дагуу баталсан техник үйлчилгээний хөтөлбөр.

--oOo--